

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2024 оны

02 дугаар сард хийсэн ажлын товч мэдээ

2024 оны 02 дугаар сарын 23

Дархан-Уул аймаг

Хонгор сумын Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Хонгор хот тохижилт ОНӨААТҮГ-ын 2023 оны 7-12 сарын санхүүгийн үйл ажиллагаанд шалгалт хийсэн тэмдэглэл, зөрчлийн жагсаалтыг тус байгууллага болон сумын Засаг даргад хүргүүллээ. Шалгалтаар илэрсэн 39,3 сая төгрөгийн зөрчлийг арилгуулж, 1.8 сая төгрөгийг төсвийн орлогын дансанд төлүүлэхээр улсын ахлах байцаагчийн 3 акт тогтоож, 32.3 сая төгрөгийн зөрчил арилгуулахаар улсын ахлах байцаагчийн 1 албан шаардлага өгч, 5.3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй анхааран ажиллах талаар холбогдох зөвлөмжийг өгч ажиллалаа.

2024 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Дархан сумын 27-р цэцэрлэгийн 2022, 2023 оны санхүүгийн үйл ажиллагаанд эрх бүхий байгууллагаас батлан гаргасан хууль эрх зүйн актын хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хууль тогтоомжийн биелэлтийг хангуулах, мэргэжлийн заавар зөвлөмж өгөх зорилгоор хяналт шалгалтыг хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар нийт 35,198.4 мянган төгрөгийн зөрчил илэрсэн ба үүнээс 4,242.7 мянган төгрөгийг төсвийн орлогын дансанд төвлөрүүлэх, 628.1 мянган төгрөгийг ажилтанд олгуулахаар Улсын ахлах байцаагчийн 5 акт тогтоож, 30,327.6 мянган төгрөгийн зөрчил арилгуулахаар Улсын ахлах байцаагчийн 1 албан шаардлага хүргүүлсэн.

Мөн санхүүгийн хяналт шалгалтыг 11-р цэцэрлэгт, дотоод аудитыг 1-р цэцэрлэг, Орхон сумын 9-р цэцэрлэгийн үйл ажиллагаанд тус тус хийж, илэрсэн зөрчлийн талаар холбогдох ажилтнуудтай сонсох ажиллагаа хийлээ. Байгууллагууд 2023 оны санхүүгийн тайланг баталгаажуулахаар аудитын байгууллагад хүргүүлсэн гэх шалтгаанаар санхүүгийн анхан шатны баримт ирээгүй байгаагаас шалгалт удаашралтай явагдаж байна.

Шарын гол сумын 17, 10-р цэцэрлэгт санхүүгийн хяналт шалгалтыг, 25-р цэцэрлэгт, 8-р цэцэрлэгт дотоод аудитыг тус тус хийхээр удирдамжийг Засаг даргаар батлуулан тухайн байгууллагуудад хүргэлээ. Энэ хүрээнд хяналт шалгалтын удирдамж, шалгалтын хүрээнд хийгдэх ажлууд, хамрах хүрээний талаар тус цэцэрлэгийн удирдлага, нягтлан бодогч нарт танилцуулж, цэцэрлэгийн үйл

ажиллагаатай танилцан, бараа материалын тооллого хийн газар дээр нь үр дүнг танилцуулсан .

Хяналт шалгалт хийх болсонтой холбогдуулан Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”-г 7 ажилтан гаргасныг хүлээн авч, бүртгэлийн дэвтэрт тэмдэглэн Авлигатай тэмцэх газрын цахим программд орууллаа.

Дотоод аудит-хяналт шалгалтын удирдлагын мэдээллийн системийг нэвтрүүлэхээр <http://audit.mof.gov.mn/> системд дотоод аудитор, байцаагчдын хүний нөөц, сургалт, аудиторуудын мэдлэг, ур чадвар, боловсрол, туршлагын мэдээлэл орууллаа.

Албан хаагчид [Хувь хүний орлогын албан татварын тайлан](#)г татварын цахим системд илгээсэн ба 7 албан хаагч ХАСХОМ-оо хугацаандаа байгууллагын ЭБАТ-д өгч баталгаажууллаа.

Тус албаны ХАСХОМ тайлангуудыг гарган баталгаажуулж, аймгийн ЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтэст хүргүүлээ.


Чанарын менежментийн тогтолцоог байгууллагын үйл ажиллагаанд нэвтрүүлэх ажлын хүрээнд цахим сургалтад хамрагдаж стандартын шаардлагын дагуу холбогдох бичиг баримтуудыг шинэчилж ажиллалаа.

Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Төрийн байгууллагын үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцооны стандартыг хэрэгжүүлж, иргэдийн хэрэгцээ, шаардлагыг ханган сэтгэл ханамжийн төвшинг дээшлүүлнэ.” гэж заасны дагуу чанарын менежментийн тогтолцоог Оргил ундрах эрдэм ХХК-аас зөвлөх үйлчилгээ авч нэвтрүүлэх үйл ажиллагааг 2023 оны 9 сараас 2024 оны 1 сар хүртэл зохион байгууллаа. 2024 оны 02 дугаар сарын 26-27-ний өдрүүдэд Мон Майнинг сертифицийшин ХХК-ний 2 аудитор тус байгууллагад ажиллан Чанарын менежментийн тогтолцоонд баталгаажуулалт хийлээ.





Байгууллагын 2024 оны дотоод сургалтын төлөвлөгөөний дагуу Архив, албан хэрэг хөтлөлт сэдэвт сургалтыг Дархан-Уул аймгийн Архивын тасгийн дарга Н.Баярбаатар тус албаны албан хаагч болон Дархан сумын ЗДТГ-ын албан хаагчдад зохион байгууллаа.



САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН АЛБА